

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.04.29

№ 1

Дархан

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц  
болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ..... хувьцаа эзэмшдэг ..... хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох ..... энгийн ширхэг хувьцааны ..... % болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компнаий тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны ..... % -ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА**



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2014.04.29

№ 2

Дархан


Компанийн санхүүгийн тайлан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 62.1.9, 62.1.14, дугаар зүйлийн заалт, “ТҮШИГ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн

**ТОГТООХ НЬ:**

3. “ТҮШИГ УУЛ” ХК-ийн гүйцэтгэх удирдлагаас оруулсан 2013 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.04.29

№ 3

Дархан

Компанийн хувьцааг хуваах тухай

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйл заалт, “ТҮШИГ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн

**ТОГТООХ НЬ:**

1. Урьд нь гаргасан нэг бүр нь 100 төгрөгний нэрлэсэн үнэтэй 434,577 ширхэг хувьцааг 1=10 ширхэг болгон хувааж нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 4.345.770 ширхэг хувьцаатай болохыг зөвшөөрсүгэй.
2. “Хувьцаа хуваах төсөл” боловсруулах, хувьцаа хуваахтай холбон хийгдэх бүхий л ажлыг зохион байгуулах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
3. Хувьцаа хуваах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.04.29

№ 4

Дархан

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “ТҮШИГ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн

**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа хуваахтай холбогдуулан компанийн дүрэмд дараах агуулгатай өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Дүрмийн 4.1, 4.2 дэх заалтыг “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүрийн **10** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **4345770** ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.” гэж өөрчлөлт оруулахыг баталсугай.
3. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг холбогдох байгуулагуудад мэдэгдэн өөрчлөлт хийлгэхийг Гүйцэтгэх захирал / ..... / -д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.04.29

№ 5

Дархан

ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 62.1.7 дугаар зүйлийн заалт, “ТҮШИГ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн

**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олонхийн санал авсан:

1. Ж.Баяраа
2. Ж.Баянтөр
3. Ж.Батсайхан
4. Л.Ганчимэг
5. Ж.Баянцогт
6. Б.Үүрийнцолмон

Нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүдээр,

1. Б.Аюуш
2. Д.Ганхуяг
3. Х.Чинболд

нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр тус тус улируулан томилусгай.

2. Компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, Гүйцэтгэх удирдлагыг удирдлагаар хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

